

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны .4. сарын 21 өдөр

№ 25/01

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

ХОС-ийн 2024 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгүүдийг тус тус удирдлага болгон “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025. оны 4. сарын 21 өдөр

№ 25/02

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний  
жилийн тайланг батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Сангийн ХОМК болох “Мандал Ассет Менежмент” ХХК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2024 оны жилийн тайланг баталсугай.
- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаа-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 4 сарын 21 өдөр

№ 25/03

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний  
жилийн тайланг батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- “Голомт банк” ХК-ийн Кастодиан банкны хэлтсийн хөрөнгө хадгалах үйлчилгээний 2024 оны жилийн тайланг баталсугай.
- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 4 сарын 21 өдөр

№ 25/04

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15 дахь хэсэг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Сангийн дүрэмд энэхүү шийдвэрийн Хавсралт 1-т заасан өөрчлөлтийг оруулсугай.
- Энэхүү шийдвэрийн 1-д заасны дагуу зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг Сангийн гүйцэтгэх удирдлага Г.Ганзоригт үүрэг болгосугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ



## САНГИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

### I. Сангийн дүрмийн хэсэгт оруулах өөрчлөлт

Одоо байгаа хэсэг	Өөрчлөн найруулах
<b>1. Өөрчлөн найруулах</b>	
“Сангийн менежер”	“Сангийн гүйцэтгэх удирдлага”
<p>4.5 Сангийн активт дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно. Үүнд:</p> <p>4.5.1 Засгийн газрын, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;</p> <p>4.5.2 Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;</p> <p>4.5.3 Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;</p> <p>4.5.4 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;</p>	<p>4.5 Сангийн активт дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно. Үүнд:</p> <p>4.5.1 Засгийн газрын, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;</p> <p>4.5.2 Нээлттэй Монгол улсын болон гадаад улсы хувьцаат компанийн хувьцаа;</p> <p>4.5.3 Монгол улсын болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаг компаний өрийн хэрэгсэл;</p> <p>4.5.4 Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаггүй компанийн өрийн хэрэгсэл;</p> <p>4.5.5 Гадаад улсын Засгийн газраас гаргасан үнэт цаас</p> <p>4.5.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;</p> <p>4.5.5. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх</p> <p>4.5.6. Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад хэрэгсэл</p>
9.2 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компаний тухай хуулийн 62 дугаар зүйл нэгэн адил хамаарна.	9.2 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооноос тогтоосон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад журамд заасан бүрэн эрхийг эдлэнэ.
9.3.5 Компаний тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооноос тогтоосон Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбосотой журмуудад заасан бусад асуудлыг шийдвэрлэх.	9.3.5 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, бусад хууль болон Хорооноос тогтоосон Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой журмуудад заасан бусад асуудлыг шийдвэрлэх.
10.3 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь гурван (3) жил байх бөгөөд улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүдийг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэдийд ч өөрчлөн сольж болох бөгөөд тэр тохиолдолд саналын эрх бүхий Сангийн нэгж эрх эзэмшигчдийн арван (10) буюу түүнээс дээш хувийн санал, шаардлага гаргаснаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.	10.3 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь таван (5) жил байх бөгөөд улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүдийг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэдийд ч өөрчлөн сольж болох бөгөөд тэр тохиолдолд саналын эрх бүхий Сангийн нэгж эрх эзэмшигчдийн арван (10) буюу түүнээс дээш хувийн санал, шаардлага гаргаснаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.
10.4.10 КомпанийнБ тухай хуулийн 11-р бүлэгт заасн их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох.	10.4.10 Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, /Энэхүү их хэмжээний хэлцэлд Компанийн тухай хуулийн 87.1. дэх хэсгийг ойлгоно
10.5 ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.	10.5 ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа танхим эсхүл цахим хэлбэрээр хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.

<i>2. Дүрмээс хасах</i>
4.7 Сан нь энэхүү Дүрэмд зааснаас өөр хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.
10.4.6 Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах
11.11.4 Хөрөнгө оруулалт хийх боломжтой байгаа хөрөнгийн талаар ТУЗ-д зөвлөх
15.1.9 Сангийн маркетингийн зардал
15.2 ХОМК-ийн Сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах зардалд доорх хамаарна. / бүхлээр нь хассан/
<i>3. Дүрэмд нэмэх</i>
4.6 Сангийн активт энэхүү дүрмийн 4.5 дах хэсэгт заасан хөрөнгө оруулалтын хэрэгслээс гадна Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооноос зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгсэл байж болно.
11.3.1 Гүйцэтгэх удирдлага нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн хугацаанд, эсхүл дараагийн гүйцэтгэх удирдлага томилогдох хүртэлх хугацаанд түүний эрхийг ХОМК-ийн гүйцэтгэх захирал, эсхүл Хороонд бүртгэлтэй хөрөнгө оруулалтын зөвлөх нь итгэмжлэлийн үндсэн дээр хэрэгжүүлж болно

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 4 сарын 21 өдөр

№ 25/05

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны  
зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх хэсэг, 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай:

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	Бичиг хэргийн зардал	2,000,000
2	ТУЗ-ийн хурлын зардал	3,000,000
3	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	10,000,000
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин /жилээр/	28,000,000
	<b>Нийт дүн</b>	<b>43,000,000</b>

- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ



# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны .4. сарын 21 өдөр

№ 25/06

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

*ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс саналыг кумулятив аргаар тоолсон болохыг тэмдэглэн, Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС /цаашид Сан гэх/-ийг үүсгэн байгуулах 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 21/009 тогтоолоор томилогдсон Сангийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болох Н.Монсор, Ц.Батсүх, Ч.Анхбаяр нарыг 5 жилийн хугацаатай улируулан сонгосугай.
2. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан улиран сонгогдож буй гишүүдийг олон нийтэд мэдээлэх, Зохицуулагч байгууллагуудад мэдэгдэхийг сангийн Гүйцэтгэх удирдлага Г.Ганзоригт даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ



# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 4 сарын 21 өдөр

№ 25/07

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 10.2, 10.3 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс саналыг кумулятив аргаар тоолсон болохыг тэмдэглэн, Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК /цаашид Сан гэх/-ийн Нэгж эрх эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 22-ны өдрийн ээлжит хурлын 006 тоот тогтоолоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр томилогдсон Р.Амаржаргалын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө буюу 2025 оны 04 сарын 21-ний өдрөөр дуусгавар болгосугай.
2. Нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн Р.Сугархүүг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр 2025 оны 04 сарын 21-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаагаар томилсугай.
3. Шинээр томиогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг олон нийтэд мэдээлэх, Санхүүийн Зохицуулах Хороонд тохиромжтой этгээдээр тодорхойлуулах, холбогдох бичиг баримтыг хүргүүлэхийг сангийн Гүйцэтгэх удирдлага Ганзоригт даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 4 сарын 21 өдөр

№ 25/08

Улаанбаатар хот

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Сангийн Нэгж эрхийн танилцуулгад  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Сангийн Нэгж эрхийн танилцуулгад энэхүү шийдвэрийн Хавсралт 1-т заасан өөрчлөлтийг оруулсугай.
- Энэхүү шийдвэрийн 1-д заасны дагуу зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг Сангийн гүйцэтгэх удирдлага Г.Ганзоригт үүрэг болгосугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ



## НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГАД ОРОХ ӨӨРЧЛӨЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Сангийн нэгж эрхийн танилцуулгын 3.2.3 дах хэсгийн “Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хязгаарлалт” хэсэгт орох өөрчлөлт

Сан нь өөрийн хөрөнгөө доорх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Үүнд:

- Засгийн газрын, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
- Нээлттэй Монгол улсын болон гадаад улсы хувьцаат компанийн хувьцаа;
- Монгол улсын болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаг компаний өрийн хэрэгсэл;
- Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаггүй компанийн өрийн хэрэгсэл;
- Гадаад улсын Засгийн газраас гаргасан үнэт цаас
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
- Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;
- Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад хэрэгсэл;

Сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоодог бөгөөд Сан нь уг хууль, журмын шаардлагад нийцүүлэн ажиллана.

**Өмнөх Сангийн нэгж эрхийн танилцуулгын 3.2.3 дах хэсгийн “Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хязгаарлалт” хэсэг**

Сан нь өөрийн хөрөнгөө доорх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Үүнд:

- Засгийн газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
- Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
- Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
- Санхүүгийн Зохицуулах Хороо болон нэгж эрх эзэмшигчдийн хурлаар зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгсэл.

Сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоодог бөгөөд Сан нь уг хууль, журмын шаардлагад нийцүүлэн ажиллана.



## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 21 өдөр

Улаанбаатар хот

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Сан” гэх)-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дугаар сарын 21-ний өдөр 10:20 цагаас 12:30 цагийн хооронд цахимаар хуралдаж, хурлын ирц, санал хураалт, асуултыг [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) вэбсайтаар хураав.

**Хурлын дарга:** Ганболдын БАТЗОРИГ

**Тооллогын комисс:** С.Батбаяр /Комиссын дарга/

Гишүүд: Г.Төгсбилэг /Ахлах дата аналит/

Б.Түвшинбаяр /Борлуулалтын ахлах менежер/

Б.Хонгорзул /Бизнес хөгжлийн менежер/

Б.Энхтуул /Хөрөнгө оруулалтын шинжээч/

**Хуралд оролцсон нэгж эрх эзэмшигч нарын тоо:** 155

**Хуралд оролцсон саналын эрхтэй нэгж эрх эзэмшигч нарын тоо:** 25,525,123 ширхэг

**Хурлын ирц:** 51.05% хувь буюу олонх.

### НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Санал хураалт авсан [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) цахим хуудсаар санал өгөх зааварчилгааг үзүүлэв.

Хурлын дарга Г.Батзориг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2025 оны 03 сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас 2024 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 21-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэн тухай, нэгж эрх эзэмшигчдийн хурлыг сангийн албан ёсны фэйсбүүк хуудас болох Mandal Ireeduin Osolt ХОС/ Мандал Ирээдүйн Өсөлт ХОС группт хийх бөгөөд хурлын ирц, санал хураалт, асуултыг [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) сайтаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тухай танилцуулав. Бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 01-ны өдөр байхаар тогтож, хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид 2025 оны 03 сарын 17-ний өдрийн дотор хүргүүлж, хурлын зарыг өдөр тутмын сониноор 2025 оны 03 сарын 17 болон 2025 оны 03 сарын 27-ны өдрүүдэд мэдээлж, хурлын материалыг брокерын компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 03 сарын 21-ны өдөр хүргүүлсэн тухай тус тус танилцуулав.

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Тооллогын комиссын дарга С.Батбаяр хурлын ирцийг танилцуулахаар болов.

- Нэгж эрх эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн нэгж эрх эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.
- Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 25,525,123 ширхэг нэгж эрх эзэмшдэг 155 нэгж эрх эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 50,000,000



ширхэг нэгж эрхийн 51.05% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

- Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй нэгж эрхийн 51.05%-ийг эзэмшигч хуралд оролцож байгаа учраас компанийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай хэмээн тогтоолыг уншив.

“Мандал Ассет Менежмент” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг нээлтийн үг хэлж, Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, сангийн ТУЗ, хөрөнгө оруулалтын хорооны үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг танилцуулж, сангийн өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэхээр ажиллаж байгаа тухай тайлбарлан хурал албан ёсоор эхлэв.

## **ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

**1 дүгээр асуудал:** Сангийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;

**2 дугаар асуудал:** Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний 2024 оны жилийн тайланг танилцуулах;

**3 дугаар асуудал:** Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний 2024 оны жилийн тайлан танилцуулах;

**4 дүгээр асуудал:** Сангийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

**5 дугаар асуудал:** Сангийн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

**6 дугаар асуудал:** Сангийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

**7 дугаар асуудал:** ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

**8 дугаар асуудал:** ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгон тухай;

**9 дугаар асуудал:** ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай;

**10 дугаар асуудал:** Сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;

**11 дүгээр асуудал:** Сангийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.

### **1 ДҮГЭЭР АСУУДАЛ:**

**Сангийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах**

**2024 оны Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланг танилцуулах**

Танилцуулсан: Г.Батзориг

Танилцуулгын гол агуулга

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК нь Голомт кастодианыг сонгож хөрөнгө хадгалах үйлчилгээг авдаг. Кастодиан банк нь ҮЦТХТ-с нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг авч тулган баталгаажуулж, Монголын Хөрөнгийн Биржид нэгж эрхийн үнэлгээг харуулж, Санхүүгийн

## МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны  
2025 оны 04-р сарын 21-ний өдрийн  
Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

Зохицуулах Хороонд сар, улирал бүр тайлангуудыг явуулах гэх мэт олон улсын хөрөнгө оруулалтын сангийн жишгээр үйл ажиллагаагаа явуулж байгааг танилцуулав.

Сангийн хөрөнгө оруулалтын багцыг хувьцаа, тогтмол орлоготой үнэт цаас буюу бонд, ХБҮЦ, мөнгөний захын хэрэгслээр бүрдүүлж байгаа, 2023 онд Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэн 60.3 тб байсан бол 2024 онд 69.08 тб болж 8.78 тб цэвэр өсөлттэй ажилласан тухай танилцуулав.

2024 оны хөрөнгө оруулалтын стратегийг танилцуулав.

- Төгрөг, ам.доллар сонголт
- Хувьцаа, бонд, хадгаламжийн харьцаа
- Хувьцааны суурь шинжилгээ - банкны хувьцаа
- Бонд - барьцаа, батлан даалт бүхий бондын багц
- Журмын хязгаарлалт
- Шүүхийн асуудал

Валютын ханшийн таамаглалд долларын эсрэг төгрөг сулрахгүй гэж үзсэн тул хөрөнгө оруулалтыг 100% төгрөгийн багц дээр байршуулсан тухай танилцуулав. Валютын дарамтын индексийг 24 макро үзүүлэлт дээр зах зээлийн нөхцөл байдал болон ханшийн дарамтыг хэмждэг тухай тайлбарлав.

Мөн сан нь ногдол ашиг суурьтай, салбарын тэргүүлэгч компаниудын хувьцааг сонгож хөрөнгө оруулалт хийдэг, 2024 оны хувьд хувьцааны багцын 73 хувийг топ банкнуудын хувьцаа, 27 хувийг топ компанийн хувьцаа эзэлж байгааг танилцуулав.

Хөрөнгө оруулалтын багцын дийлэнх хувийг бондуудад байршуулдаг. Бондын зах зээлийн үзүүлэлтүүдийг дурдав.

Хууль, эрх зүйн орчны шинэчлэлээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны журмуудад өөрчлөлт орсон тухай танилцуулж, Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС хаалттай бондод хөрөнгө оруулах боломжтой болсон гол өөрчлөлтийг дурдан, өгөөж өндөр байх боломж нэмэгдсэн тухай, журамд заасан хязгаарлалтад өөрчлөлт орсныг танилцуулав.

Монголын Хөрөнгийн Бирж ба Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС хоорондын шүүхийн маргаан эцэслэгдэн шийдвэрлэгдэж, МХБ-ийн нэхэмжилсэн дүнг 487.5 сая төгрөгөөр бууруулж чадсан тухай тус тус танилцуулав.

### Сангийн энэ жилийн онцлох үйл явдал:

- **Мөнгөний менежер цахим сэтгүүл:** Хөрөнгө оруулалт болон бизнесийн шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор валютын ханш, макро эдийн засгийн төлөв, зээл, хүүгийн түвшний судалгааг бэлтгэн хүргүүллээ.
- **Вэбсайтын шинэчлэл:** Цаг хугацаа байршлаас үл хамааран сангийн хөрөнгө оруулалтын багц болон тайланг тухай бүр авах боломжийг бүрдүүлэв.
- **Хөрөнгө оруулалтын экспог зохион байгуулав.**
- **Шүүхийн маргаан:** МХБ-ээс нэхэмжлэлтэй шүүхийн маргааныг эцэслэн шийдэж, нэхэмжилсэн дүнг 487.5 сая төгрөгөөр бууруулав.

2024 онд хөрөнгө оруулалтын багцын тайланг сар бүр 8,000 хөрөнгө оруулагчид тогтмол илгээж байгаа, нийт 1,405 харилцагчтай утсаар холбогдож сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл болон зөвлөгөө мэдээллийг тус тус өгч, хөрөнгө оруулагчдаас нийт 150 гаруй санал хүсэлт ирсэн ажлын 5-10 хоногт шуурхай шийдвэрлэсэн тухай тус тус танилцуулав.



Хурлын дарга Г.Батзориг сангийн үйл ажиллагааны танилцуулга болон ХОМК-ийн үйл ажиллагааны жилийн тайланг танилцуулж, Голомт кастодиан банкны үйлчилгээний жилийн тайланг танилцуулна уу хэмээн “Голомт банк” ХК-ийн Кастодиан банкны ажилтан Т.Бат-Ундралыг урив.

### **3 ДУГААР АСУУДАЛ:**

#### **Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг танилцуулах**

Танилцуулсан: “Голомт банк” ХК-ийн Кастодиан банкны ажилтан Т.Бат-Ундрал.

Танилцуулгын гол агуулга:

Кастодиан банк нь тусгай зөвшөөрөл эзэмшигч бөгөөд ҮЦК, ХОМК, ХОС, даатгалын компаниуд болон бусад харилцагчид үйлчилгээ үзүүлдэг. Кастодиан банк нь хөрөнгө хадгалах, тухайлсан бүртгэл хөтлөх, сангийн цэвэр активын өртгийг тооцох, эцсийн өмчлөгчийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын санд давхар хяналт тавьдаг хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилготой байгууллага юм.

Голомт кастодиан нь 2014 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа. Монголд ICS системийг ашиглаж буй цорын ганц кастодиан банк, JP Morgan Bank-ны Sub-custodian банк бөгөөд Системийн гамшгийн үед ажиллах горимын туршилтыг хагас жил тутамд зохион байгуулдаг, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг хангаж ажилладаг, мэдээллийн аюулгүй байдлын стандартуудыг хангаж ажилладаг, Банкны дотоод аудитаас тогтмол үйл ажиллагааны аудит хийгддэг.

Кастодиан нь Мандал Ирээдүйн Өсөлт сантай 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр гэрээ байгуулсан байдаг. 2022 онд 55.8 тб хөрөнгийг хадгалж байсан бол 2023 онд 60.38 тб, 2024 онд 69.08 тб төгрөгийг хадгалсан өсөлттэй ажиллаж байна.

Манай компани нь Мандал Ирээдүйн Өсөлт сантай өдөр бүр, нийт 365 удаагийн тооцоолол хийж тулган баталгаажуулж хөрөнгийн үнэ цэнийг тооцдог, хөрөнгийн үлдэгдлийн тайлан, дансны гүйлгээний дэлгэрэнгүй тайлан, шимтгэлийн тайлан гэх мэт тайлангуудыг бэлтгэдэг, Дотоодын компанийн хувьцааны 8 удаагийн 1.5 т.б төгрөгийн ногдол ашгийн төлөлт, 46 удаагийн 6.9 т.б төгрөгийн үнэлгээ бүхий хүүгийн болон эргэн төлөлтийн дүнг харилцагчийн дансанд байршуулж, Мөнгөн хөрөнгийн 369 удаагийн гүйлгээ болон 8.7 тб төгрөгийн хөрөнгө оруулалтыг гүйлгээг бүртгэсэн тухай тус тус танилцуулав.

### **4 ДҮГЭЭР АСУУДАЛ:**

#### **Сангийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах**

Танилцуулгын гол агуулга: Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК-ийн санхүүгийн тайланд Нэкса Глобал Монголиа Аудитын компани аудит хийж гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүх материаллаг зүйлийг хамруулан үнэн зөв толилуулагдсан тухай “Хараат бус аудиторын дүгнэлт”-ийг танилцуулав.

### **5 ДУГААР АСУУДАЛ:**

#### **Сангийн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах**

Танилцуулгын гол агуулга: 2025 оны 02-р сарын 18-ны өдрийн 01 тоот “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулав.

## МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны

2025 оны 04-р сарын 21-ний өдрийн

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

ТУЗ “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

### 6 ДУГААР АСУУДАЛ:

**Сангийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;**

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2025 оны 03 сарын 31-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 26/06 тоот дүгнэлтийг уншиж танилцуулав.

1. ХОС-ийн жилийн үйл ажиллагааны болон аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн асуудлаар:

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ нь 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны журам, Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам, ХОС-ийн дүрмийн хүрээнд доорх дүгнэлтийг гаргасан болно. Үүнд:

ХОС нь хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн дагуу амжилттай хийж 2024 оны 12 сарын 31-ний байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 1,381.76 төгрөгт хүрсэн байна.

ХОС нь 2024 онд 10.55 тэрбум төгрөгийн нийт орлогыг тайланд бүртгэж тайлант жилийн цэвэр ашиг 8.39 тэрбум төгрөгт хүрчээ.

2024 онд сангийн хөндлөнгийн аудитаар олон улсын “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК ажилласан бөгөөд 2025 оны 03 сарын 28-ны өдөр гаргасан дүгнэлтээр “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна гэсэн дүгнэлт гаргасан байна.

2. Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан

2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар сангийн нэгж эрх эзэмшигч 7,938 иргэн, 26 аж ахуй нэгж, 3 гадаадын иргэн, 1 гадаадын аж ахуйн нэгж байна. 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Сангийн цэвэр үнэлгээ 69.08 тэрбум төгрөг, Нэгж эрхийн цэвэр үнэлгээ 1,381.76 төгрөг байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Сангийн хөрөнгөөс 22.01 хувь нь хувьцаанд, 36.83 хувь нь Бондод, 41.16 хувь нь мөнгөний захын хэрэгсэлд тус тус байршиж байна. Нийт сангийн нэгж эрхийн 50 сая нэгж эрхээс 51.26 тэрбум төгрөгийг дотоодын иргэд, 17.81 тэрбум төгрөгийг дотоодын аж ахуй нэгж, 15.53 сая төгрөгийг гадаадын иргэн, 320 мянган төгрөгийг гадаадын ААН эзэмшиж байна.

Голомт кастодиан нь 2024 онд нийт 69.08 тэрбум төгрөгийн хөрөнгө хадгалж, Нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээний тооцооллыг 365 удаа хийж, 6 төрлийн тайлан мэдээг тогтмол боловсруулж, төлбөр тооцоо, бүртгэл, арилжаа, нэгж эрхийн арилжаа гүйцэтгэж, 7,968 нэгж эрх эзэмшигчдийн 50,0 сая нэгж эрхийг бүртгэж баталгаажуулсан байна.

3. ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан

Гүйцэтгэх удирдлага нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт болон бусад дотоод хууль журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ажилласан байна. Үүнд:



# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны  
2025 оны 04-р сарын 21-ний өдрийн  
Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

- Сангийн хөрөнгө оруулалтын мэдээллийг тухай бүр хүргэх
- Сангийн үнэ ханшийн мэдээллийг тухай бүр хүргэх.
- ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх

Иймд 2024 онд “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК-ийн хөрөнгө оруулалтын менежментийн баг төлөвлөсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэсэн тухай уншиж танилцуулав.

## 7 ДУГААР АСУУДАЛ:

### Сангийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

Сангийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр батлуулахаар Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Үүнд:

№	Зардлын төсөв	Нийт зардал /₮/
1	Бичиг хэргийн зардал	2,000,000
2	ТУЗ-ийн хурлын зардал	3,000,000
3	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	10,000,000
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин /жилээр/	28,000,000
<b>Дүн</b>		<b>43,000,000</b>

## 8 ДУГААР АСУУДАЛ:

### ТУЗ-н гишүүдийг улируулан сонгох тухай

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийг үүсгэн байгуулах 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 21/009 тогтоолоор томилогдсон Сангийн ТУЗ-ийн гишүүд болох Н.Монсор, Ц.Батсүх, Ч.Анхбаяр нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул 5 жилийн хугацаатай улируулан сонгох тухай асуудлыг хэлэлцэв.

## 9 ДҮГЭЭР АСУУДАЛ:

### ТУЗ-н гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн Нэгж эрх эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын 006 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон Р.Амаржаргал чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө буюу 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөр дуусгавар болгож, сангийн нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн Р.Сугархүүг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаагаар томилох тухай хэлэлцэв.

## 10 ДУГААР АСУУДАЛ:

### Сангийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны  
2025 оны 04-р сарын 21-ний өдрийн  
Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

Танилцуулгын гол агуулга: 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт орж улмаар 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр СЗХ-ны журмуудад өөрчлөлт орсон. Энэхүү хууль эрх зүйн зохицуулалтын шинэчлэлд нийцүүлэн дүрэмд өөрчлөлт оруулах болсныг танилцуулав.

## 11 ДҮГЭЭР АСУУДАЛ:

### Сангийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах тухай

Танилцуулгын гол агуулга: 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт орж улмаар 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр СЗХ-ны журмуудад өөрчлөлт орсон. Энэхүү хууль эрх зүйн зохицуулалтын шинэчлэлд нийцүүлэн Нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах тухай тус тус хэлэлцэв.

Ийнхүү Нэгж эрх эзэмшигчдийн хурлын материалуудыг танилцуулж дууссанаар хурлын дэгийн дагуу асуулт хариулт эхлэв.

### Асуулт, Хариулт

Хурлын дарга Г.Батзориг асуулт хариултын хэсэг эхэлснийг зарлаж нэгж эрх эзэмшигчдээс хамгийн олон давтагдсан асуултуудаас сонгож авсныг тайлбарлав.

Тооллогын комиссын дарга С.Батбаяр хурлын дарга Г.Батзоригоос асуув.

#### Асуулт 1:

Монголын Хөрөнгийн Биржтэй холбоотой шүүхийн маргаанд ялсан гэх мэдээлэл явж байна. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.

#### Хурлын дарга Г.Батзориг хариулт (товч):

Хөрөнгө оруулалтын санг анх байгуулахад хууль эрх зүйн орчин дулимаг, Монголын Хөрөнгийн Биржийн журамд заасан үйлчилгээний шимтгэл өндөр байсан. МХБ-ээс 675 сая төгрөгийг нэхэмжилж, харин бид энэ үеийн журамд заасан шимтгэл нь үндэслэлгүй, хэт өндрөөр тогтоосон гэж маргасан. бус одоогийн журамд зааснаар төлнө гэж маргасан. Шүүхийн процесс удаан үргэлжилж, Улсын дээд шүүхээс эцэслэн шийдвэрлэж бид нэхэмжлэлийн дүнг 487 сая төгрөгөөр бууруулж чадсан билээ.

#### Асуулт 2:

Сангийн өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх гэж байна вэ?

#### Хурлын дарга Г.Батзориг хариулт (товч):

Сан үүсгэн байгуулагдсанаас хойш гурван жилийн хугацаанд жилд дунджаар 13 хувийн өгөөжтэй ажилласан байна. Хэдийгээр энэ нь банкны хадгаламжийн хүүгээс өндөр байгаа ч бид өгөөжийг улам нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Хууль, эрх зүйн орчны шинэчлэлтэй холбоотойгоор өгөөж нэмэгдэх сайн нөхцөл байдал үүссэн. Сангийн хөрөнгө оруулалтын багцын хувьцааны үнэ зах зээлээс үүдэн уналттай байгаа нь сангийн өгөөжид нөлөөлж байгааг дурдах хэрэгтэй хэмээн хариулав.

#### Асуулт 3:

2025 оны эдийн засгийн төлөв байдал ямар байна вэ? Эдийн засгийн энэ нөхцөл байдалд хөрөнгө оруулалтын ямар стратеги барьж ажиллах вэ?

#### Хурлын дарга Г.Батзориг хариулт (товч):



Хятад болон Америкийн хоорондын худалдааны дайнтай холбоотой дэлхийн хөрөнгийн зах зээл тодорхой бус байдалд байна. Ийм нөхцөлд хувьцааны үнэ унадаг тул хөрөнгө оруулагчид бондын хөрөнгө оруулалтыг илүүтэй хийдэг. Монголын хөрөнгийн зах зээл Хятадын эдийн засгийн уналттай холбоотой нөлөөнд орох эсэх, бид хэрхэн өгөөжийг өндөр байлгах тухай судалгааг тогтмол хийн ажиллаж байгаа.

Хурлын дэгийн дагуу асуулт хариултын хэсэг өндөрлөж санал хураалт эхэлснийг хурлын нарийн бичиг Г.Батзориг мэдэгдэж санал хураах цаг явж эхлэв. Санал хураах, саналын үр дүнг тоолох хэсэг 40 минутын турш үргэлжилж санал хураалтын дүнг танилцуулав.

### **САНАЛ ХУРААЛТЫН ДҮН**

**Танилцуулсан:** Тооллогын комиссын дарга С.Батбаяр

Тооллогын комиссын дарга С.Батбаяр: Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Үүнд:

- 1.1 “ХОМК болох “Мандал Ассет Менежмент” ХХК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний жилийн тайланг батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,912,473.00 ширхэг нэгж эрх буюу 98.11%, татгалзсан 125,533 ширхэг нэгж эрх буюу 0.89%, түдгэлзсэн 143,007 ширхэг нэгж эрх буюу 1.01% байна.
- 1.2 “Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,816,191.00 ширхэг нэгж эрх буюу 97.43%, татгалзсан 125,533 ширхэг нэгж эрх буюу 0.89%, түдгэлзсэн 239,289 ширхэг нэгж эрх буюу 1.69% байна.
- 1.3 “ХОС-ын 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,552,219 ширхэг нэгж эрх буюу 95.57%, татгалзсан 125,533 ширхэг нэгж эрх буюу 0.89%, түдгэлзсэн 503,261 ширхэг нэгж эрх буюу 3.55% байна.
- 1.4 “ТУЗ-ийн 2025 үйл ажиллагааны зардлын төсөв батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,491,545 ширхэг нэгж эрх буюу 95.14%, татгалзсан 125,533 ширхэг нэгж эрх буюу 0.89%, түдгэлзсэн 563,935 ширхэг нэгж эрх буюу 3.98% байна.
- 1.5 “Сангийн дүрэмд хавсралтад заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,152,085 ширхэг нэгж эрх буюу 92.74%, татгалзсан 125,533 ширхэг нэгж эрх буюу 0.89%, түдгэлзсэн 903,395 ширхэг нэгж эрх буюу 6.37% байна.
- 1.6 “Сангийн нэгж эрхийн танилцуулгад хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,264,818 ширхэг нэгж эрх буюу 93.54%, татгалзсан 125,533 ширхэг нэгж эрх буюу 0.89%, түдгэлзсэн 790,662 ширхэг нэгж эрх буюу 5.58% байна.
- 1.7 “ТУЗ-ийн ердийн гишүүдийг улируулан сонгох тухай/Н.Монсор, Ц.Батсүх, Ч.Анхбаяр/” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,078,303 ширхэг нэгж эрх буюу 92.22%, татгалзсан 0 ширхэг нэгж эрх буюу 0.00%, түдгэлзсэн 1,102,710 ширхэг нэгж эрх буюу 7.78% байна.
- 1.8 “ТУЗ-ийн ердийн гишүүн Р.Амаржаргалыг чөлөөлөх тухай” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 12,948,941 ширхэг нэгж эрх буюу 91.31%, татгалзсан 0 ширхэг нэгж эрх буюу 0.00%, түдгэлзсэн 1,232,072 ширхэг нэгж эрх буюу 8.69% байна.
- 1.9 “ТУЗ-ийн ердийн гишүүнээр Р.Сугархүүг нөхөн томилох тухай” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,060,961 ширхэг нэгж эрх буюу 92.10%, татгалзсан 0 ширхэг нэгж эрх буюу 0.00%, түдгэлзсэн 1,120,052 ширхэг нэгж эрх буюу 7.90% байна.

## МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны  
2025 оны 04-р сарын 21-ний өдрийн  
Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

Хурлын дарга Г.Батзориг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй нэгж эрх эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 12 цаг 20 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

  
У.САНСАРМАА АТАР ХОТ  
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга  
МАНДАЛ  
ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ  
ХАМТЫН ХОС  
ТАНИЛЦСАН: ХХК  
  
УТ 21060636 д. 6702988  
Г.БАТЗОРИГ  
Хурлын дарга